



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/609

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Хос тэмүүлэх гарьд” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

П.Баясгалан - “Хос тэмүүлэх гарьд” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2 “Хос тэмүүлэх гарьд” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 2053
Zah A/609 Kh